

**МАЛЧНЫ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ  
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДУГНЭЛТ**

2014 оны 10 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 19 гишүүнээс Улсын Их Хуралд 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд нийгмийн шилжилтийн явцад эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн бүтцэд гарсан өөрчлөлт, мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог, хөдөлмөр, нийгмийн даатгалын талаарх хууль тогтоомжийн шинэчлэл зэргээс шалтгаалан тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлөөгүй иргэнд малчнаар ажилласан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх боломж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар малчид тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж, тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөл болзлыг хангах, нийгмийн баталгаа нь сайжрах, улмаар тэдний мал аж ахуйгаа тогтвортой суурьшилтай эрхлэх сонирхол өсөх, хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнийг сааруулахад эерэг нөлөө үзүүлэх, малчдын тэтгэврийн даатгалд хамрагдалт нэмэгдэж, шимтгэлээ нөхөн төлснөөр сангийн орлого бүрдүүлэлтийг өсгөх зэрэг ач холбогдолтой гэж төсөл санаачлагчид үзжээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ, Д.Батцогт нар малчдын тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлснөөр нийгмийн даатгалын санд учруулах ачааллыг тооцоолох, малчдад нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлөх, тооцох аргачлалыг тодорхой, ойлгомжтой болгох, ажлын хэсэгт байгуулж ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан улсын төсөвт ирэх ачаалал, төсөөллийн талаар судалгаа хийх зэрэг саналуудыг тус тус гаргалаа.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дээрх хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦООГТ